

Агуулга

Бүлэг 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
Бүлэг 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	7
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний тайлангийн гол зорилт	13
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний тайлан	14
Бүлэг 6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний тайлан	17
Бүлэг 7. ТҮҮХ, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний тайлан	17
Бүлэг 8. Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний тайлан	18
Бүлэг 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан	19
Бүлэг 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний тайлан	20
Бүлэг 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бусийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний тайлан	21

Зургийн дугаар

Зураг 1. Төслийн талбайн байршил	2
Зураг 2. “Зочдын өргөө” ХХК-ний “Зочны тохой” амралтын газар	3
Зураг 3. Талбайн барилга байгууламж	6
Зураг 4. Талбайн эргэн тойрны газар ашиглалт	8

Хүснэгтийн дугаар

Хүснэгт 1. Төслийн талбайн байршлын мэдээлэл	2
Хүснэгт 2. Төслийн талбайн газар ашиглалт	6

ХАВСРАЛТААР:

- “Зочдын өргөө”ХХК-ний гэрчилгээний хуулбар
- Тохирлын гэрчилгээ, Тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ
- Галын аюулгүй байдлын дүрэм

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн талбайн байршил

Энэхүү төсөл нь Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол 3-р багийн нутаг дэвсгэрт амралтын газрын үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Төслийн талбайн байршлын мэдээлэл

№	Салбарын дугаар	Байршил	Газарзүйн байршил		Талбайн хэмжээ /м ² /
			Уртраг	Өргөрөг	
1	Зочны тохой амралтын газар	Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол 3-р багийн нутагт Өндрийн ар	106°53'14.38"E	47°55'37.67"N	40000,0

Зураг 1. Төслийн талбайн байршил



Төсөл хэрэгжүүлэгчийн төвч танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч “Зочдын өргөө” ХХК нь 2018 онд байгуулагдаж, амралтын газрын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд давхардсан тоогоор 4000 гаруй амрагч нарт үйлчилж байна.

“Зочдын өргөө” ХХК нь байгуулагдсан цагаасаа амралтын газар, хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2024 онд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны чиглэлээ дараах 3 төрлөөр тодорхойлж үйл ажиллагаагаа илүү төрөлжүүлэн мэргэшиж байна.

- Амралтын газрын үйл ажиллагаа
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ
- Хүнсний бараа бүтээгдхүүний худалдаа, үйлчилгээ гэсэн чиглэлээр өргөжүүлэн ажиллаж байна.

Зураг 2. “ЗОЧДЫН ӨРГӨӨ” ХХК-ний “Зочны тохой” амралтын газар



Багаж, тоног төхөөрөмж

“Зочны тохой” амралтын газар нь үйлчилгээндээ хамгийн сүүлийн үеийн нийтийн хоол, технологийн багаж тоног төхөөрөмж ашиглахыг зорин ажилладаг бөгөөд тогооч, зөөгч, үйлчилгээний ажилтнуудад стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр ханганд ажиллаж байна.

“Зочдын өргөө” ХХК нь тогооч, менежер, үйлчилгээний ажилтнуудын хангамж нөхөлт болон тоног төхөөрөмжийн судалгаа, шинэчлэлтэд жил бүр 15-25 сая төгрөгийг зарцуулж байна. Үйлчилгээнд ашиглаж буй тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, машин хэрэгсэлүүдийг Япон, Солонгос, Хятад болон Монголын нийтийн хоол, худалдаа, аялал жуулчлалын салбарын зах зээлээс авч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дотоод харилцаа

“Зочдын өргөө” ХХК-ийн “Зочны тохой” амралтын газар нь 2024 онд зочин, амрагчдад ая тухтай амрах цэвэр аюулгүй орчныг бүрдүүлэх, хэрэгцээт бараа үйлчилгээг хямд боломжийн үнээр хүргэх, эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай эко хүнсний бүтээгдхүүнээр үйлчлэх, амралтын газарт зочны аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах зорилт ажиллалаа.

Боловсон хүчин, ажилчдын сургалт хөгжүүлэлт

“Зочдын өргөө” ХХК нь 2018 оноос эхэлж үйл ажиллагаа явуулан, үндсэн 2 орон тоотой, гэрээт 4 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн удирдлагаас ажилтнуудаа дэмжих, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сурч хөгжих боловсроход байнга анхаарч сургалтын төвүүдтэй хамтран ажиллаж мэргэжлийн сургалтуудыг тогтмол авч байна. Жилдээ 2 удаа хамт олныг бүрэн хамруулсан тойрон аялал, арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

Эрчим хүч, дулаан, ус хангамж

“Зочны тохой” амралтын газар нь цахилгаан эрчим хүчээ 380кВт-аар хангадаг ба өөрийн хөрөнгөөр барьсан 250КВА КТПН-ийг 2016 онд ашиглалтанд оруулан, төвлөрсөн цахилгаан хангамжийг Төв аймгийн Цахилгаан сүлжээний газартай байгуулсан гэрээний дагуу авч сар бүр төлбөрийг төлж ашиглаж байна. Зочин байрлуулах гэрүүд нь шалны болон энгийн халаалттайгаар зөвхөн хавар, зуны улиралд амрагч хүлээн авч ажиллаж байна. Жил бүр Төв аймгийн онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын байрны хяналт шалгалтанд хамрагдаж, холбогдох дүгнэлтээ гаргуулан үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн үйл ажиллагаа явуулах “Тохирлын гэрчилгээ” болон бусад зөвшөөрөл, дүгнэлтүүдийг авч хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Ус хангамж, ариутгах татуурга

“Зочны тохой” амралтын газар нь Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас “Гүний худаг гаргах зөвшөөрөл”-ийг 2018 онд авч гүний худаг гаргуулан

ашиглаж байна. Унд, хэрэглээний усаа гүний худгийн уснаас авч ашигладаг ба гарсан бохир усыг ёмкостьд хуримтлуулан бохир ус соруулах авто машинаар зөөвөрлүүлэн зайлцуулдаг байсныг өөрчилж, 2023 оноос байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөлгүй, “Бохир усыг 98 % цэвэршүүлэн хөрсөнд нь шингээх” технологи бүхий цэвэрлэх байгууламжийг суурилуулан ашиглаж байна. Амралтын газрын гал тогоо, ариун цэврийн өрөө болон ажилчдын өрөөнд ариун цэвэр, эрүүл ахуйн дүрэм журмыг баримтлан, 2023 онд Төв аймгийн Байгаль орчны газарт “Ус ашиглах дүгнэлт” гаргуулсан бөгөөд усны тоолуурыг баталгаажуулан суурилуулж, орон нутгийн төсөвт ус ашигласны төлбөрийг сар бүр төлж ажиллахаар төлөвлөж байна. Уг төлөлт нь усны хэрэглээнээс хамааран тоолуурыг үндэслэн тогтоогдоно.

Орон нутгийн төсөвт оруулах хувь нэмэр

2024 оны байдлаар хогны хураамжинд 1200,000 мянган төгрөг, цахилгааны төлбөр 12,942,000 мянган төгрөг тус тус төлсөн байна. 2024 онд сар бүрийн цахилгааны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлж ажиллалаа.

Үүнээс гадна компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ажилчдын хувцас хэрэгсэлд жилд 1200,000 мянган төгрөг, хангамжийн материалд 5.500,000 мянган төгрөг мөн багт Эх үрсийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан хандив тусламж өгдөг. Мөн орон нутгаас үйлчлэгч, хамгаалагч, тогооч ажилчдыг авч ажиллуулан 5 ажлын байраар хангаж ажиллана.

Төслийн талбайн газар эзэмших, ашиглах эрх

Төсөл хэрэгжиж буй Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол 3-р багийн нутагт байрлах “Зочдын өргөө” ХХК-ний “Зочны тохой” амралтын газар нь газрын эрх зүйн хувьд Төв аймгийн Батсүмбэр сумтай хийсэн гэрээний зохицуулалтаар газрыг ашиглаж, Төв аймгийн Батсүмбэр сумын засаг даргын 2020 оны 6-р сарын 9-ны өдрийн 04113-Б374/2020 тоот шийдвэрийн дагуу 40,000 м² газрыг 15 жилийн хугацаатай үйлчилгээний зориулалтаар эзэмших эрхийг авч үйл ажиллагааг явуулж байна. Гэрээ болон газрын гэрчилгээ кадастрын зургийг (Хавсралт 1)-с үзнэ үү.




Төслийн талбайн газар ашиглалт

Амралтын газрын үйл ажиллагааг “Зочдын өргөө” ХХК нь Төв аймгийн Батсүмбэр сумын Баянголын аманд, Баянгол 3-р багийн нутаг дэвсгэрт , нийт 4,0 га буюу 40,000 м² талбайд явуулж байна.

Хүснэгт 2. Төслийн талбайн газар ашиглалт

№	Салбарын дугаар	Байршил	Газрын талбайн хэмжээ /м ² /	Объектын талаарх мэдээлэл	Газар өмчлөх, эзэмших эрх	Тайлбар
1	Зочны тохой амралтын газар	Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт, Баянголын аманд, Баянгол 3-р багт	40000.0	Амрагчдын кемп: 11 гэр кемп: $26,7 \times 11 = 294 \text{ м}^2$ Амрагчдын кемп: 9 гэр кемп $31,9 \times 9 = 287,1 \text{ м}^2$ Барилгын суурь: 480,7 м ² Ариун цэврийн байгууламж: 79,5 м ² Үйлчилгээний заал: 216 м ² Хоол үйлдвэрлэлийн хэсэг: Халуун цех 80 м ² Харуулын байр: 13,9 м ² Ашиглаагүй сул талбай: 38,755,3 м ²	Эзэмших гэрээгээр	Амралтын газар нь: Гэр кемп-2, үйлчилгээний заал-1, халуун цех-1, газар-1, харуулын байр-1, нийтийн ариун цэврийн байгууламж-2 гэсэн зохион байгуулалттай.

Зураг 3. Талбайн барилга байгууламж



БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчин

“Зочны тохой” амралтын газар нь газрын нэгдмэл сангийн ангиллаар Хот тосгон бусад суурины газрын дэд ангилал болох амралт, аялал жуулчлалын газарт хамарагдана. Төслийн талбайгаас 21 км зайд Чингэлтэй хайрхан уул, 22,5 км зайд Горхи-Тэрэлж БЦГ, 28 км зайд Ноён уул, 34 км зайд Хан Хэнтийн ДЦГ байрлана.


Нийгэм эдийн засаг

“Зочны тохой” амралтын газар байрлах :Төв аймгийн Батсүмбэр сум нь нийт 243116 га нутаг дэвсгэртэй. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 sumaас эхнээсээ 2-д ,газар нутгийн хэмжээгээр 13-д ордог /аймгийн төвийг оролцуулахгүй/ хүн амын нягтрал хамгийн ихтэй сум юм. Сумын хүн амын 65 хувь нь запуу болон дунд насныхан, 25 хувь нь хүүхэд, 10 хувь нь ахмад настан байна. Батсүмбэр сумын нутаг дэвсгэр нь уул, ой modoор бүрхэгдсэн эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой нутаг юм. Сумын 83% нь мал аж ахуй эрхэлдэг байна.

Талбайн эргэн тойрны газар ашиглалт

Төсөл хэрэгжиж буй байршил нь суурьшлын бүс үүссэн газарт үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд эргэн тойронд ерөнхийдөө мал аж ахуй эрхэлдэг иргэд гэр, байшин барьж амьдран суудаг, хойд болон баруун хэсгээр амралтын газрууд, зүүн хэсэгт Ахмад настны үндэсний төв болон хувийн эзэмшлийн зориулалттай газрууд байна.

Зураг 4. Талбайн эргэн тойрны газар ашиглалт



Урдаас харагдах байдал



Хойноос харагдах байдал

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолтыг бэлтгэхдээ 2020 онд байгаль орчны үнэлгээ, судалгааны ЖЭМР ХХК-ийн боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг эх сурвалж болгон ашиглав.

Агаарын чанар

- “Зочны тохой” амралтын газар нь эрчим хүчээр бүрэн хангагдсан ба амрагчдын гэрүүдийг шалны халаалтаар халаах тул өвлийн улиралд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөгүй. Амралтын газраар үйлчлүүлэх амрагч, аялагчдын машин техникийн хөдөлгөөнөөс тоос шороо босч болзошгүй. 2023 онд төслийн талбайн зүүн урд хэсэг, амралтын гэрүүд, орох гарах хаалга, харуулын байрны орчимд агаарлаг хүхэрлэг хий(CO₂), азотын давхар исэл(NO₂), нийт тоос(TSP) гэсэн үзүүлэлтээр сорыц авч шинжлүүлэхэд агаарын чанарын MNS4585:2016 стандарт хэмжээнээс даваагүй буюу агаарын бохирдолгүй байна.

Гадаргын ус

- Амралтын газрын хойд талаар урсах Баянголын ус бохирдох
- Баянгол нь хур бороо их орсон учир жилүүдэд эргээ хальдаг учир үерийн усанд автаж эрсдэлтэй. Төслийн талбайн дундуур Баянгол урсана. Баянгол нь Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Бага Хэнтийн нурууны салбар Гурван чулууны сарьдаг (2356)-ийн өврөөс эх авах ба Шургуйтын гол, Сувагтын гол, Хүрхрээгийн голууд цутгана.

Газрын доорхи ус

- Газрын доорхи усны түвшин буурч, нөөц багасах
- Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг ил задгай асгалав тухайн орчмын хөрс, газрын доорхи ус бохирдох, нян бактери үржих эрсдэлтэй. Унд ахуйн хэрэглээндээ зориулж 2019 онд гүний худаг гаргасан байна. Худгийн гүн нь 30м, усны тогтсон түвшин 0,8 м. цооногийн ашиглалтын ундарга 3,5 л/с байна. Хээрийн судалгааны үеэр гүний худгаас дээж авч шинжлүүлэхэд химиин бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөвлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтууд нь “Ундны усны чанарын тандарт MNS9000:2018”-ийн шаардлага хангаж байна.

Хөрсөн бүрхэвч

- Барилга байгууламж баригдах үед тухайн орчны хөрсөн бүрхэвч эвдрэх
- Машин техникийн шатах тослох материал асгарч, гоожсоноос хөрс бохирдох
- Явган хүний зам, авто машины зогсоолын талбай байгуулаагүйн улмаас газрын гадаргын өнгөн хэсэг талхлагдах эрсдэлтэй. Төслийн талбайн

хөрсний шинж чанар, төлөв байдлыг тодорхойлох үүднээс 2 цэгт хөрсний зүсэлт хийж, 2 дээж авч хөрсний агрохимийн болон усны физик химийн шинж чанар, хүнд металл зэргийг лабораториар шинжлүүлэхэд: Хөрсний хүнд металлын шинжилгээний дунг хөрс бохирдуулагч элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019 стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй буюу хөрсний химийн бохирдолгүй байна.

Ургамал

- Явган хүний зам, авто машины зогсоолын талбай байгуулаагүйн улмаас ургамлан нөмрөг устах, дорийтох, талхлагдах
- Ой мод гал түймэрт өртөх
- Барилга байгууламж барих газар шорооны ажлын үед тухайн орчмын хөрсөн бүрхэвчтэй хамт хуулагдах эрсдэлтэй тул жил бүр хамгаалах төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй.

Амьтны аймаг

- Төслийн талбай нь суурьшлын бус үүссэн газарт байрлах тул зэрлэг ан амьтны амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй.
- .

Түүх соёлын өв

- Төсөл хэрэгжиж буй талбайн ойр орчим түүх соёлын дурсгалт өв газар байрлахгүй тул үйл ажиллагаа явуулахад эрхзүйн хувьд хориглосон зүйл заалт байхгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг

- Тухайн үйлчилгээний газартай давхцалтай тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй.Үйл ажиллагаа явуулахад эрхзүйн хувьд хориглосон зүйл заалт байхгүй байна.

Нийгэм эдийн засаг

- Нийгэм эдийн засгийн хувьд сөрөг нөлөөлөл байхгүй харин үйл ажиллагаа тогтвортой явагдсанаар орон нутгийн төсөвт оруулах хувь нэмэр, ажлын байр нэмэгдэх зэрэг зерэг нөлөөтэй.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, бууруулах арга хэмжээ, зөвлөмж

- Сөрөг нөлөөлөл**

Тус амралтын газар нь өргөжин тэлж, хүчин чадлын хэмжээ нэмэгдэхийн хирээр амрагч, аялагчдын тоо тэр хирээр өсөн нэмэгдэнэ. Сумын төвөөс амралтын газар хүртэл хатуу хучилттай зам тавихгүй тохиолдолд олон салаа шороон зам бий болох, ургамлан бүрхэвч талхлагдах, дулааны улиралд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт тодорхой цэгт үүсч болзошгүй.

• **Бууруулах арга хэмжээ, зөвлөмж**

Одоогийн ашиглаж буй саад бартаа ихтэй шороон замыг тодорхой хугацаанд хусч арчилж байх

- Төслийн хүчин чадал нэмэгдэх үед ойр тойрны ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-үүд болон орон нутгийн байгууллагатай хамтран сумын төвөөс Ахмад настны үндэстний төв хүрэх шороон замыг хатуу хучилттай болгох, нэгдсэн нэг маршрутын замаар зорчих
- **Эерэг нөлөөлөл**
- Одоогийн байдлаар 5 хүнийг амралтын газарт ажиллуулж байгаа бөгөөд цаашид төслийн үйл ажиллагаа бүрэн жигдэснээр орон нутгийн иргэдээс нэмж ажлын байраар хангахаар төлөвлөгдсөн.

Орон нутгийн эдийн засагт дараах эерэг нөлөөллийг үзүүлэхээр байна.

- Цөөн тооны ажлын байр бий болгосноор орон нутгийн ажилгүй иргэдийн тоог бууруулна.
- Улс, орон нутагт газрын төлбөр, хог хаягдлын хураамж, ус ашигласны төлбөр, ХАОАТ, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал зэргийг төлнө.



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тухайн жилээр тооцон тусгах зорилт тавилаа.

Мөн БОМТ-ийг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчны аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин, Ногоон хөгжлийн Яам-ны сайдын 2014 оны А-117 тушаалын хавсралт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг удирдлага болголоо.

Энэхүү төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл байх тул цаашид дараах үйл ажиллагааг анхаарах нь чухал.

- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах;
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж байх;
- ✓ Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг үйл ажиллагааныхаа турш баримталж ажиллах;
- ✓ Орчны тохижилт, эмх цэгцтэй байдлыг үйл ажиллагааны турш мөрдөн ажиллах;
- ✓ Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- ✓ Амралтын газраар үйлчлүүлж буй амрагчдын болон үйлчилгээний машинуудын тос масло асгарч, гоожин тухайн орчинд бохирдол учруулж болзошгүй тул хяналт тавьж ажиллах;
- ✓ Тухайн орчинд дуу чимээ гаргахгүй байх үүднээс машин техник хэрэгслийг ашиглахгүй үедээ унтрааж байх;

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Гол болон болжошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм жих нэг ж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмж ээ	Нийт зарда л (мян.т өг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж		Баримтлах эрх зүй баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8		9
Агаарын чанар									
SO ₂ , NO ₂ , нийт гоосны хэмжээ стандартадаас хэтрэх Дуу чимээ, цахилгаан соронзон орон	Автомашинаас үүдэлтэй тоосжилт үүсгэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, машин техникийг асаалттай үед унтраах, тос масло гоожихгүй байхад хяналт тавьж ажиллах, автомашиныг зогсоолд байршуулж ажиллалаа.	Зочны тохой амралтын газарт		ХАБЭА-н төсөвт суулгасан зардлаар		Жилд 1 удаа			
Сайжруулсан зам, зогсоолоос гоосжилт үүсэх	Зам, зогсоолын талбайг тордох, тоосжилтоос хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хусч тэгшлэх, хавтан суулгах ажлыг хэсэгчлэн хийлээ.	Зочны тохой амралтын газарт		Үйл ажиллагааны зардлаар		II, III улиралд			
Хөрс, газрын гадарга									
Хот суурин газрын агаарыг хянах журам M 0017-2-3-16:1988 Агаарын чанар MNS 4585:2016									

Орчны физик бохирдол	Үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, байгаль орчинд халгүй аргаар зайлцуулах арга хэмжээг авч ажиллалаа.	Сум орон нутаг, багтай хийсэн гэрээний дагуу багийн төвлөрсөн хог хаягдлын цэгт үйл ажиллагаанаас гарсан хатуу хог хаягдлыг зайлцуулах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	Сард 1 удаа хураамж төлөх (Өдөр бүр төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг зайлцуулах)		MNS5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуул бодисын ЗДХ
	Гадаргын болон газрын доорх ус					
Дэнгэг усны чөөцийг ашиглах	Худгийн шугам хоолойд тоолуур суурилуулж, сар бүр акт үйлдэж ус ашигласны төлбөрийг орон нутагт төлж ажиллалаа.	Төв аймгийн Байгаль орчны газартай ус ашиглах гэрээ байгуулах, усны тоолуур суурилуулах	1200,0	Жилийн турш		MNS 4943:2015 Хүрээл буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус Ерөнхий шаардлага MNS 6148:2010, “Усны чанар. Газар доорх усь бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хөрсөн бүрхэвч хамгаалах	Төслийн хашаанд хүн, үйлчилгээний машин, мотоциклъ явах, барилгын суурь ухсан тул хөрсний элэгдэл, доройтол үүсэхээс хамгаалах, сэргээх арга хэмжээг авч ажиллалаа.	Хог хаягдал түр хураах цэгийн суурийг бетондох, хог хаягдлыг ангилах, шингэн хаягдал ус урсахаас хамгаалах	1000,0	Жилийн турш		Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012
Ургамлан нөмрөг хамгаалах	Төслийн талбайд байх ургамалыг хамгаалах, арчлах, мод бут сөөгийг хугалахгүй байх арга хэмжээг авч ажиллалаа.	Ургамал, мод бут сөөгийг хамгаалах	Дотоод зардлаар	Жилийн турш		
Галын аюулаас урьдчилан сэргийлэх						
Гал түймрийн өрсдэл үүсэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх	Зочны тохой амралтын газрын	250,000		Үйл ажиллагааны турш	БНБД 21-04-05 дүрмийн “Галын аюулгүй байдлын

	дүрмийг үйл ажиллагааны турш мөрдөн ажиллав.	бүх кемп,гал тогоо,харуулын байр бүрд галын хорыг цэнэглэх,шалгах, нэгдсэн галын сарайг нэмж хийж байрлуулах,сана мж шинэчлэх		Нийт ажилчид			тухай” хууль, “Барилга байгууламжийн зураг т зохиох галын аюулгүйн норм ” БНБД 21-02-02
Үерийн аюулын эрсдэл үүсэх	Голын эрэг дагуу үер,уснаас болгоомжлох санамж байршуулав.	Санамжуудыг шинэчлэн байршуулах	500,000	Нийт ажилчид	Үйл ажиллагаавы турш		Гамшигийн эрсдлийн үн хийх журам,2019
Ажиллагсдын эрүүл ахуйн талаар							
ХАБЭА-н эрсдэл үүсэх	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгаалах үүднээс НБХХХ-ээр хангах, дотоод журмыг сахиж ажиллав.	Нийт ажилчид	ХАБЭА-н төсөвт суулгасан зардлаар	Нийт ажилчид	Жилд нэг удаа		Үйлдвэрийн ХАБЭА журмаар
	Ажилтнуудын эрүүл мэнд, ариун цэврийн шаардлагын стандарт хангуулан ажиллав.		Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардалд 11*50,000	550,0	Жилд нэг удаа		Эрүүл ахуйн дүрэм, журмаар
Нийгмийн хариуцлагын хүрээнд							
Нийгмийн хариуцлагын хүрээнд Батсүмбэр сумын болон нийтийн үйл ажиллагаанд байнга хамрагдах түүнд дэмжлэг туслалцаа үзүүлэх	Нийгмийн хариуцлагын хүрээнд сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг амралтын газарт амраах болон байгаль орчноо хамгаалах, бусад нийгмийн хандивын аянд санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн.	Зочдын өргөө ХХК	1000,0		Үйл ажиллагааны турш		Компаний дотоод жур
Нийт дүн			4500.0				

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Талбай орчмын халцгайрч доройтсон тул ногоон байгууламжийг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэв.	Газрын тухай хуулийн 6-р булгийн 56.6-д заасны дагуу эзэмшилд авсан газрынхаа 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгох гэсэн заалтын дагуу тухайн орчны талхлагдсан газрыг ургамалжуулах, ногоон байгууламж бий болгох, тордох	250м ² талбайд	ширхэг	1	2500,000 2500,000	5-7 сард	Амралтын газрын ногоон байгууламжийг сэргээн, тордох, нөхөн сэргээх, ургамалжуулах	
2	Орчны тохижилтыг сайжруулав.	Гадаад талбай болон явган хүний зам талбайг тохижуулах				2706,5			
	Нийт					5206,5			

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай нь суурьшлын бүсэд байрлах учир сөрөг нөлөөлөлд өртөх түүх соёлын үнэт зүйлс байхгүй.

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сэргэ нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сэргэ нөлөөллийн хамрах хүрээ	Хэм жих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүү лэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хатуу хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарах ахуйн хог хаягдлыг түр хадгалах цэгт цуглувж тогтсон хугацаанд хог хаягдлыг тээвэрлэж цэвэрлэж ажиллав.	Зочны тохой амралтын газар	тонн	100,0*12=1200,0		Сард 1 удаа төлөх, өдөр бүр зайлцуулах		Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдал тээвэрлэх устгах журам
2	Амралтын газрын үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	Амрагчдын нэг удаагийн хэрэглээний сав, ундаа усны сав бусад хог хаягдлыг тээвэрлэж ажиллав.		1-3	Хог хаягдлыг ангилан төрөлжүүлж, дахин боловсруулах сав боодлыг “Түвшинсайхан төвд нийлүүлэх				
3	Ахуйн шингэн хог хаягдал	Гал тогоо болон ариун цэврийн өрөөнөөс гарах бохир усыг зайлцуулах шугам, Эколос төхөөрөмж цэвэрлэх жилд 2-3 удаа цэвэрлүүлэв.	Зочны тохой амралтын газар		250,000*3=750,000				Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус MNS 6561:2015
Нийт							1,950.000		

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (мян.төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Зочны тохой амралтын газар эзэмшлийн талбай дотор	Жилд нэг удаа		1 45,000 45.0*3 цэгт =135.0		Хөрсний эрүүл ахуй болон хүнд металлын бохирдол байгаа эсэхийг үзэх.	MNS6341:2012, MNS5367:2004, MNS6341:2012
2	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Co гэх мэт)							MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Агаар бохирдуулагч бодис	Зочны тохой амралтын газар эзэмшлийн талбай дотор	Жилд нэг удаа	1	42,000 42.0*3 цэгт =126.0		Хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), Нийт тоосонцорын хэмжилт (TSP)	Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 0017-2-3-16:1988 Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82 Агаарын чанар MNS 4585:2016 MNS 5002:2000
4	Дуу шуугиан	Зочны тохой амралтын газар эзэмшлийн талбай дотор	Жилд нэг удаа	1	8,000 8.0*4 цэгт = 32.0		Дуу шуугианы бохирдол хэр байгааг үзэж ажилчид, амрагчдын чихэнд дуу чимээний нөлөө нөлөөлж байгаа үгүйг судлах	
5	Усны бүрэн шинжилгээ	Зочны тохой гүний худаг	Жилд нэг удаа		1 50,000 50.0*2 цэгт = 100.0		Унд ахуйн ус ажилчид, амрагчдын эрүүл ахуйг хангаж буйг тогтооно.	Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018
Нийт							393,000	

БҮЛЭГ 10. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он	3	4	5	
1	2	6	7				
1	ТЖБОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулав.	Дотоод нөөц бололцоогоор	2024 он 12 сар	Захирал	Тухайн жилд сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлыг тусгах		
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөв.		2024 онд	Хуульч	Компанийн зүгээс баримтлах байгаль орчны бодлоготой болох		
3	Жил бүрийн БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын удирдлагаас тухай бүрт нь шийдвэрлэж өгсөн.	ТЖБОМТ-нд тусгагдсан зардал	Жил бүрийн 1, 2,3-р улиралд багтаан	Захирал	Нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах	Захирал	3Г-аас хэрэгжүүлж байгаа “Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд”
4	Ирэх жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад	1000,000	2024 он 12 сар				
5	“Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд” “Зочны тохой” амралтын газрын талбайгаас гаднах сум, багын эзэмшилийн газар болох зам дагуу 100м2 талбайд мод тарихад	100*10,000=1000,000	2024 оны 2,4 улиралд	Захирал			
	Нийт	2,000,000					

БҮЛЭГ 11. 2024 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжүүлэх тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (мян.төг)	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
	“Зочдын өргөө” ХХК, БОАЖЯ	Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах (Тайлан хэлбэрээр)	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт	12-р сарын 20-ээс өмнө өгөх	Зардал шаардахгүй	Үйл ажиллагаа хариуцсан захирал	БОАЖЯ-нд хянуулах
ЗОЧНЫ ТОХОЙ амралтын газар							
1	Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв			4500,0			3500,0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв			5206,5			4206,5
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв			1950,0			1950,0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв			393,0			385,0
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв			2000,0			2000,0
2024	онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн нийт төсөв			14049,5			13049,5

Хавсралт 1. Асгаралтын иж бүрдэл





















